



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/38

Улаанбаатар хот

Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.19 дэх заалт, Иргэний нисэхийн ерөнхий газрын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 5.15 дахь заалт, Зам, тээврийн хөгжлийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн А/98, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/189 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтийн сангийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Хэнтий аймгийн Өндөрхаан нисэх онгоцны буудлыг шинэчлэн барих төсөл”-ийн Багц-I буюу Зам, тээврийн хөгжлийн яам болон “Барилга эрч” ХХК хооронд байгуулсан барилга ажил гүйцэтгэх 154 дугаартай гэрээт ажил, Багц-II буюу Зам, тээврийн хөгжлийн яам болон “Дабльо Экс Пи” ХХК, “Энхтөгөл бэх” ХХК-ийн түншлэл хооронд байгуулсан аэродромын ажил гүйцэтгэх 293 дугаартай гэрээт ажлын хэрэгжилтэд техник технологийн хяналт тавих, Хэнтий аймгийн Дадал “Дэлүүн болдог” нисэх буудлын зорчигч үйлчилгээний барилга байгууламжийг барих Зам, тээврийн хөгжлийн яам болон “Биг монголиа билдинг” ХХК-тай байгуулсан “Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Дэлүүнболдог нисэх буудлын барилгын /Хэнтий, Дадал сум/ ажил гүйцэтгэх 181 дугаартай гэрээт ажлын хэрэгжилтийг хангах, хяналт тавьж ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн
дарга:

Б.Ганхуяг

(Иргэний нисэхийн ерөнхий газрын Агаарын
навигаци, нисэх буудлын бодлого зохицуулалтын
газрын Нисэх буудал хариуцсан менежер)

Гишүүд:

Ч.Баттүвшин

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Гэрэл суулт,
цахилгаан хангалтын албаны Цахилгаан хангалтын
хэсгийн ахлах инженер)

Д.Цэрэндондов

(“Өндөрхаан” нисэх буудлын дарга)

Ц.Шижир-Эрдэнэ

(“Буянт-Ухаа” олон улсын нисэх буудлын
Аэродромын хэсгийн ахлах инженер)

Ж.Билэгсайхан

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Аж ахуйн
үйлчилгээ, дулаан, сантехникийн албаны Аж ахуй,
барилга засварын хэсгийн Барилгын ахлах инженер)

Ч.Чинбат

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Аж ахуйн
үйлчилгээ, дулаан сантехникийн албаны дулаан
сантехник, агааржуулалтын хэсгийн Ахлах инженер)

Г.Ууганцэрэн

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Аж ахуйн
үйлчилгээ, дулаан, сантехникийн албаны Аж ахуй,
барилга засварын хэсгийн Барилгын инженер)

Нарийн бичгийн
дарга:

Х.Рэнцэнпил

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө
оруулалт, захиалагчийн албаны Төлөвлөлт,
гүйцэтгэлийн тасгийн инженер)

2.Гэрээт ажлуудын явцад техник технологийн хяналт хэрэгжүүлэх,
хөндлөнгийн хяналт хийлгэхтэй холбогдон гарах зардлыг тухайн гэрээт ажлын
захиалагчийн хяналтын зардлаас зарцуулахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар
(Д.Хатанбаатар)-т, Иргэний нисэхийн үндэсний төв /Н.Батсайхан/-д зөвшөөрсүгэй.

3.Гэрээт ажлын хяналтыг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсэг
/Б.Ганхуяг/-т, ажлын хэсгийн үйл ажиллагаанд шаардлагатай холбогдох

дэмжлэгийг шуурхай үзүүлж, энэ тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д тус тус даалгасгай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/187 дугаартай тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА